



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/42

Арвайхээр

**Газар эзэмших эрхийн гэрчилгээний  
хугацааг сунгах тухай**

Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2012 оны а/139 дүгээр захирамжаар газар эзэмших эрх авсан, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа нь дууссан иргэн Цэдэн-Ишийн Одгэрэл (ЙЮ74041263)-ийн хүсэлтийг харгалзан Арвайхээр сумын 13 дугаар баг, Т.Намнансүрэнгийн 1 дүгээр гудамжны 103 тоотод байрлах үйлчилгээний зориулалттай 860м<sup>2</sup> газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 15 жилийн хугацаагаар сунгасугай.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа нь сунгагдсан иргэнтэй холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100098